



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/380

Арвайхээр сум

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөгжимт драмын театрын дээврийн засвар үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Нацаг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)

Гишүүд:  
Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Г.Гантөмөр (Оновчтой хөгжил ТББ-ын тэргүүн)  
(зөвшилцсөнөөр)

Ц.Соёлбадрах (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:  
Ч.Өлзийхутаг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хорооны дарга (Б.Нацаг)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Өлзийхутаг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



6223 11 0736

D:My Doc. Zahiramj. Zasag darga